



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/29

Булган сум

Түүхэн замналын ном бүтээх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.25, 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын түүхэн замналын номыг төрийн албаны ахмад ажилтнуудаар бүтээлгэж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах, аймгийн архивд хадгалан үлдээх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

2. Түүхэн замналын номыг бичих, хэвлэхэд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын тамгын газрын зохих зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

